



ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Эрүүгийн хэрэг¹)

ТАНХАЙН СЭДЛИЙГ ХУВИЙН СЭДЛЭЭС ЯЛГАЖ ЗҮЙЛЧИЛСЭН ТУХАЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: № 9-УД22-2-К1

Шүүхийн шийдвэрийн огноо: 2022 оны 04-р сарын 21-ний өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шат болон 2, 3-р давж заалдах шатны шүүхийн шийдвэрүүдэд өөрчлөлт оруулж, шүүгдэгчийн ялыг хөнгөрүүлэн зүйлчилж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

2019 оны 02 дугаар сард шүүгдэгч А.В.В. нь хохирогч А.С.-гийн байшингийн цонхыг чулуугаар хагалан, нэвтрэн орж хохирогчийн эрүүл мэндэд хохирол учруулалгүй цохин, хоёр телевиз болон ханын гэрлийг хагалжээ. Мөн шүүгдэгч нь хохирогчийг заналхийлж 1300 рубль өгөхийг тулган шаардахад, хохирогч өөрт байсан 1000 рублийг өгсөн байна.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. 2020 оны 03 дугаар сард Нижегород мужийн Павловск хотын шүүх (анхан шатны шүүх) А.В.В.-д дээрэм (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 161 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн «г» заалт²) болон танхайн сэдлээр эд зүйлсийг санаатайгаар устгасан хэргээр (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 162 дугаар зүйлийн 2 дахь хэсэг³) дөрвөн жил хагасын хугацаатай хорих ял оноожээ.

2. 2 дугаар давж заалдах болон 3 дугаар давж заалдах шатны шүүхүүд дээрх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр нь үлдээж шийдвэрлэсэн бөгөөд уг шийдвэрийг эсэргүүцэн А.В.В. нь ОХУ-ын Дээд шүүхэд гомдол гаргасан. Тэрээр хяналтын шатны шүүхэд гаргасан гомдолдоо, “доод шатны шүүхүүд түүний үйлдлийг танхайн сэдлээр

¹ Шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: http://vsrf.ru/stor_pdf.php?id=2111486

² ОХУ-ын Эрүүгийн хуулийн 161 дүгээр зүйл. Дээрэм. 2.Үйлдэгдсэн дээрэм (Грабеж, совершенный) : г) *амь нас эсхүл эрүүл мэндэд аюултай бус аргаар хүчирхийлэл хэрэглэн, эсхүл ийм хүчирхийлэл үйлдэхээр заналхийлсэн бол долоо хүртэлх жилээр хорих ял оногдуулна.*

³ УК РФ Статья 162. Разбой 2. Разбой, совершенный группой лиц по предварительному сговору, а равно с применением оружия или предметов, используемых в качестве оружия, - наказывается лишением свободы на срок до десяти лет.

(шууд орчуулбал: ОХУ-ын Эрүүгийн хуулийн 162 дугаар зүйл. Танхайрах 2. *Бүлэг этгээд урьдчилан тохиролцож, түүнтэй тэнцүү зэвсэг эсвэл эд зүйлс хэрэглэн тэдгээрийг зэвсгийн хувьд ашиглан танхайрсан бол арван жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулна.*)

Агуулгын хувьд орчуулбал: ОХУ-ын Эрүүгийн хуулийн 162 дугаар зүйл. Танхайрах 2. *Бүлэг этгээд урьдчилан тохиролцож зэвсэг эсхүл эд зүйлс ашиглан танхайрсан бол арван жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулна. Этгээд нь зэвсэг эсхүл эд зүйлс хэрэглэн тэдгээрийг зэвсгийн хувьд ашиглан танхайрсан бол арван жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулна.*

үйлдсэн гэж буруу дүгнэсэн, учир нь эд зүйлсийг санаатайгаар дээрэмдэх (илээр хулгайлах) зорилготой байсан” гэсэн байна.

3. ОХУ-ын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн шүүгч нарын бүрэлдэхүүн А.В.В-ийн хяналтын журмаар гаргасан гомдлыг үндэслэлтэй гэж үзсэн. Тус шүүх бүрэлдэхүүн “А.В.В. дээрмийн үеэр А.С.-ийн хоёр телевиз, ханын гэрлийг хагалан, эргэн засах боломжгүйгээр устгасан нь ямарваа зорилгогүй, шалтгаангүй үйлдэгдсэн үйлдэл юм. А.В.В. нь дээрх үйлдлүүдийг танхайн сэдлээр үйлдээгүй бөгөөд анхнаасаа санаатайгаар хохирогчийн мөнгийг дээрэмдэх (илээр хулгайлах)⁴ зорилготой байсан ба тус зорилгодоо хүрэхийн тулд дээрмийн үеэр хохирогчийн эд зүйлсийг устгасан. Иймд хувийн сэдлээр эд зүйлс устгасан үйлдэл болохыг харуулж байгаа ба доод шатны шүүхүүд А.В.В.-гийн дээрх үйлдлийг танхайрах сэдлээр үйлдсэн гэж дүгнэх ёсгүй байсан” гэх үндэслэлээр, түүнд ОХУ-ын Эрүүгийн хуулийн 167 дугаар зүйлийн 2 болон 1 дэх хэсгүүдийн дагуу⁵ гурван жил долоон сарын хугацаатай хорих ял оноожээ⁶.

Орчуулсан: С. Жансая
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн
Үндсэн хууль, олон улсын эрх зүйн судлаач

⁴ ОХУ-ын Эрүүгийн хуулийн 161 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу “дээрэм” гэж бусдын эд хөрөнгийг илээр хулгайлахыг хэлнэ. Энэхүү хураангуйд ашигласан ОХУ-ын хяналтын шатны тогтоолын эх хувийн зарим хэсэгт нь шүүгчид “дээрэмдэх” гэдэг үгийг “илээр хулгайлах” гэж бичсэн нь “дээрэм” гэдэг нэр томъёоны ОХУ-д ашиглагддаг албан ёсны тодорхойлолтыг ашигласантай холбоотой болно.

⁵ ОХУ-ын Эрүүгийн хуулийн 167 дугаар зүйл. Эд зүйлсийг санаатайгаар устгах эсхүл гэмтээх.

1. Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах эсхүл гэмтээх, хэрвээ эдгээр үйлдлийн улмаас тодорхой хэмжээний хохирол учирсан бол- хоёр жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулна. (Жич: уг зүйлийн энэхүү хураангуйд ашигласан хэсгийг л орчуулсан болно.)

2. Үүнтэй адил гэмт үйлдлүүдийг танхайн сэдлээр, галдан шатаах, дэлбэлэх эсхүл бусад олон нийтэд аюултай хэлбэрээр эсхүл болгоомжгүй байдлаас болж хүний амь нас хохирсон эсхүл бусад хүнд үр дагаварт хүргэсэн бол таван жил хүртэлх хугацаагаар албадан ажил хийлгэх эсхүл мөн хугацаагаар хорих ял оногдуулна.

⁶ Уголовный кодекс Российской Федерации от 13.06.1996 № 63-ФЗ // Собрание законодательства РФ. - 17.06.1996. - № 25. ст.2954 // Официальный интернет – портал правовой информации <http://www.pravo.gov.ru> (дата обращения: 12.06.2023) // (ОХУ-ын Эрүүгийн хууль 1996 оны 06-р сарын 13-ны өдрийн № 63 - XX // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга. – 1996.06.17. - №25. // Хууль эрх зүйн мэдээллийн албан ёсны интернэт портал <http://www.pravo.gov.ru>) (сүүлд үзсэн: 2023.06.12).